



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
БИЕЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар A/07

Улаанбаатар хот

“Мөрөөдлийн гоол 2022-2023” өсвөрийн  
хөлбөмбөгийн дүүргийн аварга шалгаруулах  
тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Баянзүрх дүүргийн “Мөрөөдлийн гоол 2022-2023” өсвөрийн хөлбөмбөгийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг Ерөнхий боловсролын сургуулиудын хөлбөмбөгийн гадаа талбайд 2023 оны 03 дугаар сарын 25-наас 26-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Арга хэмжээний зардалд 2,050,000 (Хоёр сая тавин мянган) төгрөгийн төсвийг хавсралтаар баталж, Спортын тэмцээн уралдааны зардлаас гаргахыг нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Спортын хэлтсийн дарга (Ю.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



ДОТГОНСҮРЭН

Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2023 оны 02 дугаар сарын 02 ны өдрийн А.Х. тушаалын хавсралт



ТӨСӨВ

2023 оны 02 дугаар сарын 02

Улаанбаатар хот

“Мөрөөдлийн гоол 2022-2023” өсвөрийн хөлбөмбөгийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээн

№	Спортын тэмцээний төрөл	Зардлын нэр төрөл	Жин, зай, насны ангилал		Багийн дүн		Нийт үнэ
			Тоо ширхэг	Нэгж үнэ	Тоо ширхэг	Нэгж үнэ	
1	“Мөрөөдлийн гоол 2022-2023” өсвөрийн хөлбөмбөгийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээн	Мөнгөн шагнал	5	100000	-	-	500,000
			5	90000	-	-	450,000
			5	80000	-	-	400,000
		Шүүгч	10	70000	-	-	700,000
			Нийт				2,050,000